

## 7 хоногийн мэдээ

1. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Нэгдсэн эмнэлгийн өрөх тасагт нярайн стандарт, халдвар хамгаалал, эмчилгээний чанар аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийж эмнэлгийн мэргэжилтэнүүдээс гардан үйлдлийн шалгалт авч ажиллаж байна.
2. “Эцэг эхчүүд өсвөр үеийнхний талаар юуг мэдэж байх ёстой вэ?”сэдвээр орон нутгийн 21 цагийн радио, “Монгол Заман” сонинд мэдээлэл хүргүүлсэн.
3. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдөр заралсан.
4. “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдвээр орон нутгийн олон нийтийн радиогоор ярилцлага өгсөн.
5. Мейрим ӨЭМТөв, Толбо сумын эрүүл мэндийн төвүүдэд сүрьеэтэй 2 өвчтөнийг гэрээгээр шилжүүлж, үргэлжлэх шатны эмчилгээг хийлгэж байна.
6. 4-р улиралын үрьеэтэй өвчтөнүүдийн хавьтлын судалгаагаар нийт тохиолдол 4, үүнд хавьтлын тоо 4, сүрьеэтэй илэрсэн тохиолдлын тоо 4% изониазидын эмчилгээнд хамрагдсан 0-5 настай хүүхэд 3 байна.
7. Баяннур сумын ЭМТөвд одоо 4 хүүхэд хэвтэн эмчүүлж байгаа.Биеийн байдал нь сайжирсан байгаа.
8. Баяннуур сумын дотуур байранд үртгэгдсэн хоолны хордлогын сэжигтэй 80 хүүхдийн тандалт суда лгаанд дүн шинжилгээ хийж ажилласан.
9. Хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг харьяа эрүүл мэндийн бүх байгууллагууд, хоолны үйлчилгээний 18 байгууллага, Боловсрол соёл, урлагийн газарт хүргүүлж ажилласан.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 41

Амьд төрөлт - 41

Амьгүй төрөлт- 0

Дутуу төрөлт - 2

Нялхсын эндэгдэл - 3

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-0

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 1

Гэрийн төрөлт- 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 52 дугаар долоо хоногт нийт 4159 хүн үйлчлүүлсний 183(4,4%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0,3%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (232)-ийн дотор 21 буюу 9 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 2,5 %-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 373 дуудлагын 84 (22,5 %-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 6,6%-иар өссөн үзүүлэлтэй байна.